



МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2018 он 02 дугаар  
сарын 28-ны өдөр

Дугаар ХЭГ/397


Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
С.ЭРДЭНЭ ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Оюутолгой ордын ашиглалтын талаар Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж тавьсан Таны асуулгын хариуг холбогдох байгууллагаар бэлтгүүлэн үүгээр хүргүүлж байна.

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга



Г.ЗАНДАНШАТАР

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН С.ЭРДЭНЭЭС ЕРӨНХИЙ САЙД  
У.ХҮРЭЛСҮХЭД ХАНДАЖ ТАВЬСАН АСУУЛГЫН ХАРИУ

**Нэг.Оюутолгой ордын нөөцийн талаар**

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт орших Оюутолгойн зэс-алтны бүлэг (Оюут, Хюго Дамметт, Херуга) орд нь MV-006709 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Оюу толгой, MV-015225 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Жавхлант, MV-015226 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Шивээ толгой нэртэй ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд тус тус оршиж байна.

Анх 2007 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл /цаашид "ЭБМЗ" гэх/-ийн хуралдаанаар "Айвенхоу Майнз Монголий Инк" ХХК (одоогийн "Оюу Толгой" ХХК)-ийн 6709А ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд орших Оюутолгойн зэс-алтны порфирын бүлэг ордын Өмнөд Оюу болон Хюго Дамметын ордуудын хэмжээнд 1997-2005 онуудад хийсэн хайгуулын үр дүн, нөөцийн тооцооллыг хэлэлцсэн байна. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дээрх хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэсэн 16-01 дугаар дүгнэлтийг үндэслэн Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын даргын 2007 оны 264 дугаар тушаалаар Оюутолгойн бүлэг ордын Өмнөд Оюугийн ордод А+В зэргээр бодитой ба боломжтой нөөцийг хүдэр 930 сая тонн, түүнд 0,50% дундаж агуулгатай зэс 658 мянган тонн, 0,36 г/т дундаж агуулгатай алт 236,4 тонноор Ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэсэн байна. "Айвенхоу Майнз Монголий Инк" ХХК нь дээрх нөөцийг бэлтгэх хайгуулын ажилд нийт 183,39 тэрбум төгрөг зарцуулсан байна.

"Айвенхоу Майнз Монголий Инк" ХХК нь 3148Х, 3150Х тусгай зөвшөөрөл бүхий хайгуулын талбайнуудад хийсэн хайгуулын ажлыг нэгтгэн 2000-2008 онуудад хийсэн хайгуулын ажил болон нөөцийн тооцооллыг 2009 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлжээ. ЭБМЗ нь Оюутолгойн бүлэг орд (Өмнөд Оюу, Хюго Даммет, Оюу толгой, Хойд Хюго, Херуга ордууд)-ын геологийн үр ашигтай нөөцийг А+В+С зэргээр 2,675 сая тонн хүдэр, түүнд 0,95%-ийн дундаж агуулгатай зэс 25,36 сая тонн, 68,78 г/т дундаж агуулгатай молибдений 81,6 мянган тонн, 0,38 г/т дундаж агуулгатай алтны 1028 тонн, тодорхой нөхцөлд ашигтай нөөц А+В+С зэргээр 3,775 сая тонн хүдэр, түүнд 0,52 % дундаж агуулгатай зэс 19,66 сая тонн, 57,55 г/т дундаж агуулгатай молибдений 75,5 мянган тонн, 0,21 г/т дундаж агуулгатай алт 810 тонноор тус тус бүртгэх тухай 15-1 дүгээр дүгнэлтийг гаргасны дагуу Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2009 оны 167 дугаар тушаалаар Монгол Улсын ашигт малтмалын нөөцийн нэгдсэн тоо бүртгэлд бүртгэсэн байна. Мөн мөнгөний 12 тонн нөөц дагалдаж бүртгэгджээ.

Түүнчлэн, Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын дээрх тушаалаар Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын даргын 2007 оны 264 дүгээр тушаалаар бүртгэсэн өмнөх нөөцийг бүртгэлээс хассан байна. "Айвенхоу Майнз Монголий Инк" ХХК нь 2000-2008 оны хайгуулд 171,7 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Уул уурхайн сайдын 2013 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн 230 дугаар тушаалаар Оюутолгойн бүлэг ордын Өмнөд Оюу болон Херуга ордуудад 2009-2011 онуудад хийсэн хайгуулын үр дүнд тогтоосон нөөцөд шинжээчийн хэсэг

томилон дүгнэлт гаргуулжээ.

Оюутолгойн бүлэг ордын Өмнөд Оюу болон Херуга ордуудад 2009-2011 онуудад хийсэн хайгуулын тайланг ЭБМЗ-ийн 2014 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн стр-08/14 дүгээр дүгнэлтийг үндэслэн гаргасан Ашигт малтмалын газрын даргын 2015 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн Н/10 дугаар тушаалаар ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд доорх нөөцийг бүртгэсэн.

1.Оюутолгойн зэс-алтны бүлэг ордод 2009-2014 онуудад гүйцэтгэсэн хайгуулын ажлаар бүлэг ордын нийт баттай, бодитой болон боломжтой (A+B+C) зэргийн нөөцийг 6,43 тэрбум.тонн хүдэрт 0.69%-ийн дундаж агуулгатай 44,4 сая.тонн зэс, 0.30 гр/тоннын дундаж агуулгатай 1903 тонн алт, 1.85 г/тонн-ын дундаж агуулгатай 11896 тонн мөнгө, 120 г/тоннын дундаж агуулгатай 205 мян.тонн молибден (зэсийн дүйцүүлсэн агуулгыг дунджаар 0.88%)-ийн нөөц бүртгэсэн. Үүнээс Оюутолгой нэртэй MV-006709 тоот тусгай зөвшөөрлийн талбайд Оюутын орд, хойд Хюго, өмнөт Хюго, хойд Херуга хэсгийн эдийн засгийн үр ашигтай баттай, бодитой болон боломжтой (A+B+C) зэргийн нөөцийг 2,781 тэрбум.тонн хүдэрт 0.92%-ийн дундаж агуулгатай 25,65 сая.тонн зэс, 0.29 г/тоннын дундаж агуулгатай 809 тонн алт, 2.19 г/тонн-ын дундаж агуулгатай 6086 тонн мөнгө, 128г/тонн-ын дундаж агуулгатай 10 мян.тонн молибден (зэсийн дүйцүүлсэн агуулгыг дунджаар 1.10%), тодорхой нөхцөлд эдийн засгийн үр ашигтай баттай, бодитой болон боломжтой (A+B+C) зэргийн нөөцийг 1,658 тэрбум.тонн хүдэрт 0.50%-ийн дундаж агуулгатай 8,372 сая.тонн зэс, 0.20 гр/тонн-ын дундаж агуулгатай 329 тонн алт, 1.48 гр/тоннын дундаж агуулгатай 2,460 тонн мөнгө, 77 гр/тоннын дундаж агуулгатай 3 мян.тонн молибден (зэсийн дүйцүүлсэн агуулгыг дунджаар 0.92%) гэж тооцоолсон байна.

2.Жавхлант нэртэй MV-015225 тоот тусгай зөвшөөрлийн талбайд хамрагдах Херуга ордын Херуга хэсгийн эдийн засгийн үр ашигтай боломжтой (C) зэргийн нөөцийг 562,284 сая.тонн хүдэрт 0.46%-ийн дундаж агуулгатай 2,598 сая.тонн зэс, 0.48 гр/тонн-ын дундаж агуулгатай 269 тонн алт, 1.67 гр/тоннын дундаж агуулгатай 941 тонн мөнгө, 137 гр/тоннын дундаж агуулгатай 77 мян.тонн молибден, (зэсийн дүйцүүлсэн агуулгыг дунджаар 0.78%) тооцож тодорхой нөхцөлд эдийн засгийн үр ашигтай боломжтой (C) зэргийн нөөцийг 1,137 тэрбум.тонн хүдэрт 0.35%-ийн дундаж агуулгатай 4,026 сая.тонн зэс, 0.32 гр/тоннын дундаж агуулгатай 366 тонн алт, 1 25 гр/тоннын дундаж агуулгатай 1421 тонн мөнгө, 102 г/тоннын дундаж агуулгатай 115 мян.тонн молибден, (зэсийн дүйцүүлсэн агуулгыг дунджаар 0.57%) гэж тооцоолсон байна.

3.Шивээ толгой нэртэй MV-015226 тоот тусгай зөвшөөрлийн талбайд хамаарагдах Хойд Хюгогийн үргэлжлэл хэсгийн эдийн засгийн үр ашигтай бодитой болон боломжтой (B+C) зэргийн нөөцийг 193,980 сая.тонн хүдэрт 1.55%-ийн дундаж агуулгатай 3,011 сая.тонн зэс, 0.55 гр/тоннын дундаж агуулгатай 107 тонн алт, 4.03 гр/тоннын дундаж агуулгатай 782 тонн мөнгө, (зэсийн дүйцүүлсэн агуулгыг дунджаар 1.90%) тодорхой нөхцөлд эдийн засгийн үр ашигтай бодитой болон боломжтой (B+C) зэргийн нөөцийг 101,551 сая.тонн хүдэрт 0.75%-ийн дундаж агуулгатай 765 мян.тонн зэс, 0,23 гр/т дундаж агуулгатай 23 тонн алт, 2.03 гр/тонн дундаж агуулгатай 207 тонн мөнгө (зэсийн дүйцүүлсэн агуулгыг дунджаар 0.57%) нөөцийг тооцсон байна.

Мөн "Оюу Толгой" ХХК нь 2009 онд Монгол Улсын Ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэгдсэн геологийн нөөцөөс 2012-2013

онуудад 38.6 сая.тонн хүдэр, 167.4 мян.тонн зэс, 11.5 тонн алт, 42.9 тонн мөнгийг тус тус олборлосон байна. Энэхүү олборлосон нөөцийг 2014 оны бүртгэгдсэн нөөцөөс хасаж хөдөлгөөн хийсэн болно.

Оюутолгой үйлдвэрлэлийн усны үндсэн гол эх үүсвэр нь Гүний хоолойн усны орд бөгөөд энд тогтоогдсон гүний усны нөөц нь хэмжээний хувьд хангалттай, ашиглалтын нөөц 870 л/с байна.

### **Хоёр.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнээс тавьсан асуулгын асуудал бүрээр бэлтгэсэн хариултын талаар**

*Асуулт 1. 2013 оноос хойш өнгөрсөн таван жилийн турш зэс, алт, мөнгө зэргээс бүрдсэн 10 орчим тэрбум ам.долларын баялаг гадагшаа гарсан ба удахгүй далд уурхай бүрэн хэмжээгээр ажиллаж эхлэх үед жилд 10 тэрбум ам.доллар болж өсөх мэдээлэл байдаг. Өнгөрсөн хугацаанд Монгол Улсын төсөвт оруулсан татварын задаргааг дэлгэрэнгүй байдлаар гаргаж, Оюутолгойгоос жилд хэдэн тонн хүдэр, баяжмал, баялаг олборлодог, гадагшаа хэдэн тонн нь гарсан зэрэг статистик үзүүлэлт. Оюу Толгойн борлуулалтын орлого хаана төвлөрч, хэрхэн ямар зориулалтаар ашиглаж байгаа талаарх мэдээлэл, тооцоог гаргаж танилцуулах;*

**Хариулт:**

#### **Борлуулалтын талаар:**

**2013 онд:** “Оюу Толгой” ХХК-ийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа 2013 оноос эхэлсэн бөгөөд тухайн онд 20.2 сая тн хүдэр боловсруулж, 290 мянган тн зэсийн баяжмал үйлдвэрлэсэн. Баяжмал дахь зэсийн дундаж агуулга 26.4%, алтны дундаж агуулга 16.5 гр.тн, мөнгөний дундаж агуулга 52.4 гр.тн байсан ба баяжмал дахь зэс 76.7 мянган тонн, алт 157 мянган унц буюу 4.9 тн, 488.8 мянган тонн буюу 15.2 тн байсан. Тайлант жилд 59.4 сая ам.долларын борлуулалт хийсэн бөгөөд Монгол Улсад 158 сая ам.долларын татвар төвлөрүүлсэн байна.

**2014 онд:** Хүдэр 27.9 сая тн боловсруулж, 563.6 мянган тн зэсийн баяжмал үйлдвэрлэсэн ба баяжмал дахь зэсийн дундаж агуулга 26.3%, алтны дундаж агуулга 32.5 гр.тн, мөнгөний дундаж агуулга 49.3 гр.тн байсан ба баяжмал дахь зэс 148.4 мянган тонн, алт 589 мянган унц буюу 18.3 тн, 893 мянган тонн буюу 27.8 тн байсан. Тайлант жилд 1,945.7 сая ам.долларын борлуулалт хийсэн бөгөөд Монгол Улсад 142.8 сая ам.долларын татвар төвлөрүүлсэн байна.

**2015 онд:** Хүдэр 34.5 сая тн боловсруулж, 788.5 мянган тн зэсийн баяжмал үйлдвэрлэсэн бөгөөд баяжмал дахь зэсийн дундаж агуулга 25.6%, алтны дундаж агуулга 25.8 гр.тн, мөнгөний дундаж агуулга 48.3 гр.тн байсан ба баяжмал дахь зэс 202.2 мянган тонн, алт 653 мянган унц буюу 20.3 тн, 1,223 мянган тонн буюу 38 тн байсан. Тайлант жилд 1,878.7 сая ам.долларын борлуулалт хийсэн бөгөөд Монгол Улсад 239.7 сая ам.долларын татвар төвлөрүүлсэн байна.

**2016 онд:** Хүдэр 38.3 сая тн боловсруулж, 846.6 мянган тн зэсийн баяжмал үйлдвэрлэсэн бөгөөд баяжмал дахь зэсийн дундаж агуулга 24.5%, алтны дундаж агуулга 12.8 гр.тн, мөнгөний дундаж агуулга 56.4 гр.тн байсан.

Баяжмал дахь зэс 201.3 мянган тонн, алт 300 мянган унц буюу 9.3 тн, 1,420 мянган тонн буюу 44.1 тн байсан. Тайлант жилд 1,411.0 сая ам долларын борлуулалт хийсэн бөгөөд Монгол Улсад 203.4 сая ам.долларын татвар төвлөрүүлсэн байна.

**2017 онд:** 41.2 сая тн хүдэр боловсруулж, 787.4 мянган тн зэсийн баяжмал үйлдвэрлэсэн. Баяжмал дахь зэсийн дундаж агуулга 21.8%, алтны дундаж агуулга 4.9 гр.тн, мөнгөний дундаж агуулга 41.9 гр.тн байсан ба баяжмал дахь зэс 157.4 мянган тонн, алт 114.3 мянган унц буюу 3.5 тн, мөнгө 973.9 мянган унц буюу 30.3 тн байна. Тайлант жилд 1,112.0 сая ам.долларын орлого хүлээн авч Монгол Улсад 179.8 сая ам.долларын татварыг төвлөрүүлээд байна.

“Оюутолгой” ХХК нь 2013-2017 онд нийт 6,279.4 сая ам.долларын борлуулалт хийж, Монгол Улсад албан татвар, хураамж хэлбэрээр 923.7 сая ам.доллар төлсөн байна.

**Үйлдэрлэл болон албан татвар, хураамж, орлогын талаар:**

Хүснэгт-1

	Хэмжих	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он
Боловсруулсан хүдэр	Сая.тн	20.2	27.9	34.5	38.3	41.2
Үйлдвэрлэсэн баяжмал	зэсийн Мян.хуурай. тн	290.0	563.6	788.5	846.6	787.4
Баяжмалын дундаж агуулга (зэс)	%	26.4	26.3	25.6	24.5	21.8
Баяжмалын дундаж агуулга (алт)	Гр.тн	16.8 52.4	32.5	25.8	12.8	4.9
Баяжмалын дундаж агуулга (мөнгө)	Гр.тн		49.3	48.3	56.4	41.9
<b>Үйлдвэрлэсэн баяжмал дахь металлууд:</b>						
Зэс	Мян.тн	76.7	148.4	202.2	201.3	157.4
Алт	Мян.унц	157.0	589	653	300	114.3
	тн	4.9	18.3	20.3	9.3	3.5
Мөнгө	Мян.унц	488.8	893	1,223	1,420	1,255
	тн	15.2	27.8	38.0	44.1	30.3
<b>Татвар хураамж, борлуулалтын орлого, зардал:</b>						
Борлуулалтын нийт орлого	\$ сая	59.4	1,945.7	1,887.7	1,411.0	1,112.0
Нийт зардал	5 сая	1,499.3	1,148.8	1,055.7	1,156.0	1,667.1

Нийт татвар, хураамжийн дүн	\$ сая	185.4	228.7	471.2	362.1	392
-----------------------------	--------	-------	-------	-------	-------	-----

## Хүснэгт-2

" ОЮУ ТОЛГОЙ " ХХК -Н ТАТВАР, ХУРААМЖ, ТӨЛБӨРИЙН МЭДЭЭ					
	2017		2010 - 2017		
	TOTAL MNT-000	TOTAL IN USD	TOTAL MNT-000	TOTAL IN USD	
1 АМНАТ	132,497,109	53,901,730	651,693,581	320,366,349	
2 Орлогын албан татвар	189,917	78,353	2,070,495	1,282,765	
3 Гадаад төлбөрөөс суутгасан татвар	17,983,308	7,481,205	380,146,674	194,693,791	
4 ХОАТ - цалин, иргэдээс суутгасан	34,653,189	14,240,798	155,529,158	85,498,131	
5 Тээврийн хэрэгсэлийн татвар	87,377	35,895	427,387	245,899	
6 Газар, ус, зам, элс ашигласны төлбөр	18,101,140	7,424,931	88,719,248	47,650,658	
7 Гаалийн татвар, хураамж	29,882,614	12,243,265	211,622,809	134,072,396	
8 Үл хөдлөх хөрөнгийн татвар	19,548,914	8,030,994	52,331,803	25,252,491	
9 НӨАТ /оршин суугч бусаас суутгасан/	59,490,468	24,372,224	358,726,657	212,930,276	
10 НӨАТ /гаальд төлсөн/	60,044,264	24,600,819	432,271,598	275,501,853	
11 Татварын бусад төлбөр, торгууль	19,002,984	7,745,941	46,465,393	24,984,229	
12 Лицензийн төлбөр	546,772	221,771	3,201,628	1,777,093	
<b>Нийт төлсөн татварын дүн</b>	<b>392,028,054</b>	<b>160,377,927</b>	<b>2,383,206,430</b>	<b>1,324,255,931</b>	
Үүнээс : Улсын төсвийн орлого	319,493,657	130,586,492	2,086,008,584	1,165,853,620	
Нийслэлийн татвар	17,658,231	7,258,410	75,587,191	41,641,589	
Өмнөговь аймгийн төсөв	54,876,166	22,533,025	221,610,655	116,760,722	
13 Байгал орчны нөхөн сэргээлтийн барьцаа			874,361	615,101	
14 Нийгмийн & ЭМ-ийн даатгал	45,500,000	18,658,010	216,991,720	120,262,088	
15 Гадаад ажиллагсдын зөрүүгийн төлбөр /Ханбогд сум/			13,999,236	10,076,701	
16 Зөвшөөрөл, виз	1,749,657	715,663	13,967,176	8,759,970	
17 Ажлын байрны хөтөлбөрт төлбөр /ХХУ газар/			29,346,827	21,474,961	
<b>Нийт төлбөрийн дүн</b>	<b>439,277,711</b>	<b>179,751,600</b>	<b>2,658,385,750</b>	<b>1,485,444,753</b>	
18 Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн НӨАТ	161,590,385	66,239,821	785,041,232	469,761,162	
<b>ДҮН</b>	<b>600,888,095</b>	<b>245,991,421</b>	<b>3,443,426,982</b>	<b>1,955,205,914</b>	

### Мөнгөн хөрөнгийн орлого, зардлын талаар:

"Оюу Толгой" ХХК нь 2010-2017 онуудад 5,700.9 сая ам.долларыг үйл ажиллагааны орлогоор, 4,345.2 сая ам.долларыг төслийн санхүүжилт (гуравдагч этгээдийн авсан зээл, цаашид "ТС" гэх)-ээс, 6,818.0 сая ам.долларыг хувь нийлүүлэгчдийн зээлээр, 10.6 сая ам.долларыг нэмэлт орлого зэргээр нийт 17,453.2 сая ам.долларын мөнгөн хөрөнгийг хүлээн авсан байна.

Дээрх орлогоос 7,813.4 сая ам.долларыг үндсэн үйл ажиллагааны зардалд, 239.5 сая ам.долларыг ил уурхайн хөрөнгө оруулалтын зардалд, 2,184.0 сая ам.долларыг баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулахад, 634.5 сая ам.долларыг хайгуулийн зардалд, 1,996.4 сая ам.долларыг далд уурхайн бүтээн байгуулалтын зардлыг санхүүжүүлэхэд, 4,009.0 сая ам.долларыг хувь нийлүүлэгчдийн одоогийн зээл, түүний хүүгийн төлбөрт 1,274 сая ам.доллар, төслийн санхүүжилтийн хүүгийн зардалд 208 сая ам.доллар, 1485.4 сая ам.долларыг татвар, төлбөр, хураамжид тус тус зарцуулаад байна.

Мөн "Оюу Толгой" ХХК-ийн ТЭЗҮ-д тооцсоноор, далд уурхайгаас хүдэр олборлож эхлэх үеийн хамгийн өндөр борлуулалт 2025 онд тохиох бөгөөд энэ нь ойролцоогоор 4,939.0 сая ам.доллар байхаар төсөөллийг гаргасан. Далд

уурхайгаас хүдэр олборлож эхэлсэн үеэс хойшхи жилийн борлуулалтын дундаж орлого 2,277 0 сая ам.доллар ба 2013-2017 онуудын дундаж борлуулалттай харьцуулахад 45 орчим хувиар өсөх хандлага ажиглагдаж байгаа болно.

**Асуулт 2.** "Оюу Толгой" компани "Рио Тинто" компаниас 8 тэрбум ам.долларын зээл авсан учраас жилд 560 сая ам.доллар, өдөрт 1,5 сая ам.доллар төлдөг, уурхайн орлого өдөрт 5,4 сая ам.доллар байдаг боловч урсгал зардал, удирдлагын болон бусад зохиомол зардал асар их байдаг гэх мэдээллийг тодруулах;

**Хариулт:**

**Санхүүжилтийн талаар:**

"Оюу Толгой" ХХК-ийн санхүүжилт нь 2010 оноос хойш 2016 оны 6 дугаар сарын 29-ний өдрийг хүртэл өссөн дүнгээр энгийн хувьцаа 2,317 сая ам.доллар, давуу эрхийн хувьцаа 900 сая ам.доллар (2010-2012), хувь нийлүүлэгчдийн одоогийн зээл 679.5 сая ам.доллар, өрийн бичиг 195.4 сая ам.доллар, хувь нийлүүлэгчдийн зээл-1 нь 1,802 сая ам.доллар, хувь нийлүүлэгчдийн зээл-2 нь 4,141 сая ам.доллар байсан. 2016 оны 5 дугаар сарын 24-ний өдөр гуравдагч этгээдээс төслийн санхүүжилтийн зээл 4,323 сая ам.доллар авч, өмнө нь хуримтлагдаад байсан хувь нийлүүлэгчдийн зээл түүний хүүгийн төлбөрт 4,274 сая ам.доллар, үйл ажиллагааны орлогоос 2014-2015 онуудад 1,009 сая ам.доллар төлөөд байна. /Үүний задаргааг хавсралт дахь хүснэгтээс харна уу./

**1. Хувь нийлүүлэгчдийн одоогийн зээл** нь нийтдээ 679.5 сая ам.доллар бөгөөд 2010 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн хүү тооцож эхэлсэн бөгөөд нийт хуримтлагдсан хүүгийн зардал 322 сая ам.доллар болсныг 2016 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар үндсэн төлбөрийг хүүгийн хамт төлж барагдуулсан байна.

**2. Өрийн бичиг** болох 195.4 сая ам.долларын гэрээг 2010 оны 03 дугаар сарын 18-ны өдөр байгуулсан бөгөөд Хөрөнгө оруулалтын гэрээ хүчин төгөлдөр болох өдөр буюу 2010 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөс хойш тооцсон хүүгийн зардал 82 сая ам.доллар болсныг 2014 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар үндсэн дүнг хүүгийн хамт төлж барагдуулсан.

**3. Хувь нийлүүлэгчдийн зээл-1** 2011 оны 2 дугаар сараас эхлэн авч, нийт зээлийн дүн 1,802.5 сая ам.доллар, хуримтлагдсан хүүгийн зардал 702 сая ам.доллар болсныг 2016 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар үндсэн дүнг хүүгийн хамт төлж барагдуулсан.

**4. Хувь нийлүүлэгчдийн зээл-2** 2011 оны 12 дугаар сараас эхлэн авч, нийт зээлийн дүн 3,371 сая ам.доллар, 2016 оны 5 сарын 24-ний өдрийн байдлаар хуримтлагдсан хүүгийн зардал 917,9 сая ам.доллар байснаас 770 сая ам.долларыг зээлийн үндсэн дүнд хөрвүүлж мөн тодорхой хүүгийн зардлыг эргэн төлж тэдгээрээс суутгах татварыг улсын төсөвт төвлөрүүлсэн.

2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 2,809 сая ам.долларын үндсэн зээл, 330,1 сая ам.долларын хуримтлагдсан хүүгийн үлдэгдэлтэй байна. "Далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө"-ний 5.5 дахь заалтын дагуу Эргэн дуудсан хувь нийлүүлэгчдийн

зээл 2016 оны 10 дугаар сарын 13-ны өдрөөс 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд 720 сая ам.долларын үндсэн дүн, 30,4 сая ам.долларын хуримтлагдсан хүүгийн дүнтэй байна.

### **Хувьцааны санхүүжилтийн талаар:**

2010 онд 108,5, 2011 онд 1,266, 2012 онд 633,6, 2013 онд 310,0, 2017 онд 280,3 сая ам.долларын хувьцааны санхүүжилт хийсэн ба 2017 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар нийт дүн нь 2,598 сая ам.доллар байна. Үүнээс Монголын талын Хувьцаа эзэмшигч "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-д ногдох хүү тооцогдож байгаа хувьцааны санхүүжилтийн үндсэн дүн нь 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 846,3 сая ам.доллар, хуримлагдсан хүү нь 387,7 сая ам.доллар, нийт 1,234 сая ам.доллар байна.

Гэхдээ 34%-д тооцож байгаа Санхүүжилтийн үндсэн дүн болон түүний хүүгийн төлбөрийг Нэмэлт, өөрчлөлт оруулж, дахин тодотгосон Хувь нийлүүлэгчдийн гэрээ (НӨОДТХНГ)-ний 11.4(д) заалтын дагуу зөвхөн "Оюу Толгой" ХХК-иас хүлээн авах ногдол ашгаараа барагдуулахаар заасан байдаг.

**Асуулт 3.** *Монгол Улсын эдийн засгийн хямралын хүндрэл шалтгаан болох валютын нөөцийн хомсдлыг арилгахын тулд Монголын баялгийн орлогыг Монголоор дамжуулах ёстой. Гэтэл Олон Улсын Валютын Сан нэг компанийн эрх ашгийг Монгол Улсын эрх ашгаас дээгүүрт тавьсан алхам хийсний учрыг тодруулах. Энэ асуудалд Засгийн газрын байр сууринаас та хэрхэн хандаж байгаа талаар;*

### **Хариулт:**

#### **Оюутолгой төслийн Хөрөнгө оруулалтын гэрээ (ХӨОГ)-ний**

9.4 дэх заалт "Хөрөнгө оруулагч нь Монгол Улсын болон бусад улсын арилжааны банкинд данс нээж сонгосон валютаараа чөлөөтэй, саадгүйгээр олон улсын гүйлгээ хийх эрхтэй. Энэхүү Гэрээний 9.10.5-ын дагуу хөрөнгө оруулагчийн эдлэх эрхийг хөндөхгүйгээр Монгол Улсын дотоодод бараа үйлчилгээний төлбөрийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 1-д заасны дагуу Монголбанкны зөвшөөрлийн дүнд гадаад валютаар төлбөр хийх эрхийг Хөрөнгө оруулагчид олгоогүй бол Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм журмын дагуу Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгтээр хийнэ",

9.10 дахь заалт. Хөрөнгө оруулагч дараахь эрхийг эдэлнэ:

9.10.3. Бүтээгдэхүүний экспорт, борлуулалт, солилцооноос гадаад улсад опсон бүх орлогоо гадаад улсад хадгалах болон чөлөөтэй зарцуулах;

9.10.4. Бүтээгдэхүүний экспорт, борлуулалт, солилцооноос Монгол Улсад олсон бүх орлого/үүнд ногдол ашиг болон бусад төрлийн хуваарилалт орно/ болон гадаад улсад хийх аливаа бусад төлбөр /үүний дотор үндсэн зээл болон хүүгийн төлбөр/-ийг гадаад улс руу саадгүй шилжүүлэх болон чөлөөтэй зарцуулах;

9.10.5. гадаадад үйл ажиллагаа явуулдаг өөрийн Гэрээт гүйцэтгэгч, Туслан гүйцэтгэгч болон Монгол Улсын иргэдэд гадаад валютаар төлбөр



хийх;

9.10.6. Хэрэв өөрөө хүсвэл Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг өөрийн сонгосон арилжааны банкинд гадаад валютын данс. нээж болно /энэ нь заавал биелүүлэх үүрэг болохгүй/. гэж зааснаар Хөрөнгө оруулагч талд холбогдох эрхийг олгосон байдаг.

**Асуулт 4.** Дэлхий дээр зэсийн нөөц ховордож байхад манай улсын роялти ердөө таван хувь байна. Нэмэгдсэн өртгийн болон гаалийн зэрэг татваруудыг Оюутолгойн гэрээгээр 30 жил царцаасан. "Оюу Толгой" компани Монгол Улсын нутаг дэвсгэр дээр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу бусад аж ахуйн нэгжийн адил татвараа төлсөн тохиолдолд Монгол Улсын эдийн засагт нэмэгдэх орлогын дүн мэдээний талаар;

**Хариулт:**

ХӨОГ-ний 3.13 дахь заалтад "Хөрөнгө оруулагч нь энэхүү Гэрээ байгуулсан өдөр хүчин төгөлдөр мөрдөж байсан Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.3.2-т заасны дагуу Гэрээт талбайгаас олборлож худалдсан, худалдахаар ачуулсан, эсхүл өөрөө ашигласан бүх Бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 5 /тав/ хувиар тооцож ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг төлөх бөгөөд төлбөрийг тогтворжуулна." гэж заасны дагуу Монгол Улсад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр(АМНАТ)-ийг тогтмол 5%-иар төлж байгаа бөгөөд 2013-2017 онуудад улсын төсөвт 320.4 сая ам.долларын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлсөн байна.

**Асуулт 5.** Оюутолгойгоос жилд ойролцоогоор 25 тонн алт гаргах тооцоо бий. Энэхүү алтыг Монгол бие даасан захиран зарцуулах эрхтэйгээр гэрээний нөхцөлд оруулсан. Аливаа улсад алт тухайн улсын валютын сангийн эх үүсвэр гэдэг утгаараа эрдэнэсийн сангийн хөрөнгөд бүртгэлтэй байх ёстой. Оюу Толгой жилд 780 мянган тонн баяжмалыг экспортолж байгаа Хөрөнгө оруулалтын гэрээнд Монголд зэс хайлуулах үйлдвэр барих асуудлыг судална гэсэн утгатай заалт байдаг Хэрвээ зэс хайлуулах үйлдвэр барьчихвал баяжмалаас алтыг нь ялгаад Монгол банкинд байршуулж, валютын эх үүсвэрээ өргөтгөх, арвижуулах боломж бий. Оюу Толгойн хүдэрт зэс, алт, мөнгө, молибден бусад дагалдах үнэт металлууд агуулагдаж буйг шалгадаг мэргэжлийн лаборатори өнөөдрийг хүртэл байхгүй байна. Зэсийн хүдэрт агуулагддаг кобальт, селен, рени, теллур, хүнцэл зэрэг ховор металлуудын үнэ дэлхийн зах зээл дээр өсч байгаа. Тухайлбал. зөвхөн нэг кг рени 2600 ам.доллар, кобальт 20 ам.доллар, селен 100 орчим ам.доллар. теллур 110 ам.доллараас дээш үнээр худалдаалагдаж байна. Эдгээрийг сайжруулсан бат бөх ган үйлдвэрлэхэд ашиглагддаг тул машин техникийн салбарт онцгой эрэлттэй байдаг. Энэ асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар?

**Хариулт:**

**Зэсийн баяжмал хайлуулах үйлдвэр болон лабораторийн талаар:**

Хөрөнгө оруулалтын гэрээний 3.19-т "Засгийн газраас бичгээр хүсэлт гаргасан бол үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эхэлснээс хойш 3 /гурав/ жилийн дотор Хөрөнгө оруулагч Үндсэн үйл ажиллагаанаас гаргасан ашигт малтмалын баяжмалын бүтээгдэхүүнийг металл болгох зэс хайлуулах үйлдвэрийг /цаашид

"Хайлуулах үйлдвэр" гэх/ Монгол Улсад барих ажиллуулах эдийн засгийн боломжийн талаарх судалгааны тайланг боловсруулна", мөн ДУББСТ-ний 3.5 дахь заалтад "Зэс хайлуулах үйлдвэрийг Монгол Улсад барьж байгуулах, ажиллуулах эдийн засгийн боломжийн талаарх судалгааны тайланг "Оюу Толгой" ХХК нь 2016 оны 9 дүгээр сараас өмнө боловсруулна. Энэхүү судалгааг гаргаснаар "Оюу Толгой" ХХК-ийг ХөОГ-ний 3.19-ийн дагуу хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэнд тооцох бөгөөд энэ нь "Оюу Толгой" ХХК-ийн ХөОГ-ний дагуу хүлээсэн бусад эрх, үүрэгт нөлөөлөхгүй" гэсэн байдаг. Эдгээр заалтуудтай холбоотойгоор "Оюу Толгой" ХХК нь "Монголд зэс хайлуулах үйлдвэр барих ажиллуулах эдийн засгийн боломжийн талаарх" судалгааны тайланг боловсруулан 2016 оны 8 дугаар сарын 31-ний өдөр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлсэн бөгөөд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын тушаалаар судалгааны тайланг хүлээн авах, дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Сангийн яам, Байгаль орчин, аялал жуучлалын яам, Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн төслийн нэгж, "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийн төлөөллийг оролцуулан байгуулан ажилласан.

Монгол Улсын Засгийн газрын зүгээс Оюутолгой төслийн талбайн орчимд зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барихаар төлөвлөн Ерөнхий Сайдын 2016 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 114 дүгээр захирамжаар зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барьж байгуулах төслийн хөрөнгө оруулагчтай хамтран ажиллах талаар яриа хэлэлцээ хийж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулан ажилласан. Ажлын хэсгийн дүгнэлтийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай" Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 88 дугаар тогтоолоор Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийг Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт байгуулах тухай Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны саналыг дэмжиж, үйлдвэр байгуулахад хөрөнгө оруулж хамтран ажиллах хөрөнгө оруулагчийг сонгох, хөрөнгө оруулагчтай байгуулах гэрээний талаар яриа хэлэлцээ хийх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулан ажлын явц, үр дүнг Засгийн газарт тухай бүр танилцуулж байхыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Сангийн яам, Үндэсний хөгжлийн газарт даалгасан болно.

Тус үйлдвэрийн усны асуудлаар "Хэрлэн гол дээр урсацын тохируулга хийх төслийн тухай" Засгийн газрын 2017 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 232 дугаар тогтоолоор Өмнийн говьд байгуулагдах томоохон бүтээн байгуулалт, үйлдвэрлэл, дэд бүтцийн болон бусад төслүүдийн усан хангамжийн асуудлыг шийдвэрлэх "Хэрлэн гол дээр урсацын тохируулга хийх төсөл"-ийг хэрэгжүүлэхэд шаардагдах ТЭЗҮ, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийлгэх ажлыг шуурхай зохион байгуулах, шаардагдах санхүүжилтийг улсын төсөв, гадаадын зээл, тусламжийн эх үүсвэрээр шийдвэрлэх арга хэмжээ авахыг Байгаль орчин, аялал жуучлалын яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Сангийн яаманд тус тус даалгаж, холбогдох байгууллагууд энэ талаар ажиллаж байна.

Одоогоор Оюутолгой төслийн талбай дээр "АПС" олон улсын лаборатори болон "Геологийн төв лаборатори" ТӨҮГ нь экспортод гаргаж байгаа бүтээгдэхүүнээс дээж аван шинжилгээг гүйцэтгэж байгаа бөгөөд "Геологийн төв лаборатори" ТӨҮГ нь Засгийн газрын 2013 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 44 дүгээр тогтоолын дагуу Оюутолгойн зэс, алтны ордоос экспортод гаргах

баяжмалд хөндлөнгийн хяналтын шинжилгээ хийх ажлыг гүйцэтгэж байна.

Оюутолгойн Баяжуулах үйлдвэрийн шинжилгээний лаборатори нь 2012 онд ашиглалтанд орж, үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд хоногт 200-250 ширхэг дээж хүлээн авч төрөл бүрийн Геохимийн шинжилгээг хийж гүйцэтгэдэг ба дараах төрлийн дээжүүдэд шинжилгээ хийдэг. Тухайлбал, ил уурхайн хүдрийн дээж буюу тэсэлгээний цооногийн дээжинд - Аи, Си, Ад, Ре, Аз, 5,С,Р, исэлдсэн зэс болон чийг тодорхойлно. Баяжуулах үйлдвэрийн процессын хяналтын дээжинд-Си, Ре, 5, Аз, эцсийн баяжмалын дээжинд - Аи, Си, Ад, Ре, Аз, 5, Р, Сб, Рь, Нд, чийг болон ширхэглэл тодохойлох шигшүүрийн шинжилгээ хийдэг. Металлургийн туршилтын дээжинд-Аи, Си, Ад, Ре, Аз, 3, Р, Рь тодорхойлдог, Савласан зэсийн баяжмалын дээжинд-Аи, Си, Ад, Аз болон Р-ийн шинжилгээнүүдийг хийдэг байна.

***Асуулт 6. Австралийн компани усны нөөц судлаад 15 жилийн нөөцтэй гэж тогтоосон. Говь нутагт усны асуудал маш хурцаар тавигддаг Монголын говьд гүний усыг нөхөн сэргээх боломжгүй. Усны нөөц төрийн мэдэлд байх ёстой Гэтэл Усны тухай хуульд "тухайн хайж олсон ЭЗЭН нь гүний усыг захиран зарцуулах эрхтэй" байх заалт оруулж, "Айвенхоу Майнз" компани 30 жил усны нөөцийг эзэмшихээр болсон. Энэ нь Монгол Улсын үндсэн хуультай харшилж байгаа туп энэ асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар;***

#### **Хариулт:**

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 6.1-д "Монгол Улсын иргэнд өмчлүүлснээс бусад газар, газрын хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг төрийн өмч мөн бөгөөд төрийн эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөл, эрхийн бичгээр ашиглахаас бусад тохиолдолд халдашгүй байна.", 6.2-т "Хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын иргэн, хуулийн этгээд байгалийн баялгийг зохих төлбөр, хураамжийг төлж, гэрээ, тусгай зөвшөөрөл буюу эрхийн бичгийн дагуу ашиглаж болно." гэж заасан байдаг.

Оюутолгой төслийн хувьд Оюутолгойн ордоос зэс, алт олборлох, боловсруулах төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ (2006 оны 5 дугаар сар), Гүний хоолойн газрын доорх усны нөөцийг Оюутолгой төсөлд ашиглахад байгаль орчинд учирч болзошгүй нөлөөллийн үнэлгээний 2005 оны тайлангийн нэмэлт тодотгол, Шивээ толгой ордоос алт, зэс олборлох төслийн БОНБНУ-ий тайлан (2009он), Ундайн сайрын элс ашиглах төслийн БОНБНУ (2018 он) зэрэг 36 байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ батлуулж, жил бүр байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянуулж, тайланг зохих журмын дагуу дүгнүүлэн ажиллаж байна.

Хөрөнгө оруулалтын гэрээ болон бусад хууль, тогтоомжийн дагуу Оюутолгой төслийн хүрээнд нийт 34 худгийг унд ахуй, баяжуулах үйлдвэр, Оюутолгой-Гашуун Сухайт болон Оюу Толгой-Ханбогд сумын замын барилгын ажил мод үржүүлгийн газар, Оюутолгойн уурхайн талбайн усны хэрэгцээнд ашиглахаар 2016 оны 6 дугаар сарын 7-ны өдөр Монгол Улсын Усны тухай хуулийн 28.4, 28.6, 28.9, 28.11,29.1,29.2, Хөрөнгө оруулалтын гэрээний 6.17 дахь заалтад тус тус заасны дагуу, Галба-Өөш Долоодын говийн сав газрын захиргааны даргын 2014 оны А/17 дугаар тушаалыг тус тус үндэслэн Галба-Өөш Долоодын говийн сав газрын захиргаатай ус ашиглах гэрээг 2016 оны 6 дугаар

сарын 7-ны өдрөөс эхлэн 2040 оны 6 дугаар сарын 07-ны өдөр хүртэл нийт 25 жилийн хугацаатай байгуулан үйл ажиллагаа явуулж байгаа болно.

“Усны тухай” хуулийн 4.1-д “Монгол Улсын нутаг дэвсгэр дэх усны нөөц нь стратегийн үнэт баялаг мөн.” 26.1-д “Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, гадаад улсын хуулийн этгээд нь тодорхой зориулалт, хугацаа, болзол нөхцөл заасан ус ашиглах зөвшөөрөл, гэрээний үндсэн дээр хууль тогтоомжийн дагуу ус ашиглах эрхтэй байна.” гэж заасан байдаг.

Оюу толгой төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2009 оны 22 дугаар тушаалаар “Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт орших Гүний хоолойн газрын доорх усны ордын нөөцийг үйлдвэрлэлийн В+С<sub>1</sub> зэргээр 870 л/с гэж баталсан. Усны нөөцийн зөвлөлийн 2015 оны 2015/03 тоот тушаалаар Гүний хоолойн газрын доорх усны нөөцийг 918 л/с гэж өөрчлөн баталгаажуулсан.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь гүний хоолойн газрын доорх усны ордын цооногууд дээр байрлуулсан мониторингийн сүлжээгээр усны нөөцийн ашиглалтын байдалд байнгын хяналт тавьж байгаа бөгөөд 2017 оны жилийн эцсийн байдлаар усны түвшний өөрчлөлтөд сөрөг нөлөөлөл үзүүлсэн мэдээлэл бүртгэгдээгүй байна.

Улсын Их Хурлаас 2012 онд баталсан Усны тухай хуулийн 28.9-д зааснаар стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглах үед аж ахуйн нэгжүүдэд ус ашиглах зөвшөөрлийг ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацаагаар олгож байгаа болно.

Монгол Улсын Засгийн газар болон “Айвенхоу майнз Монголиа” ХХК хоорондын Хөрөнгө оруулалтын гэрээний 6.17-т “Хөрөнгө оруулагчийн хүсэлтийн дагуу Ус ашиглах гэрээг /Усны зөвшөөрлөөр баталсан усны нөөцийг оролцуулан/ Усны тухай. Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн тухай бопон бусад хууль тогтоомж, дүрэм журамд заасны дагуу байгуулахад Засгийн газар дэмжлэг үзүүлнэ. Оюу толгойн орд стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамрагдсан тул Хөрөнгө оруулагчтай Ус ашиглах гэрээг Усны тухай хуулийн дагуу **30 /гуч/ жилээр байгуулж**, уг гэрээг 20 /хорь/ жилийн хугацаагаар тухай бүр сунгаж болно”, 6.13.2-т “энэхүү Гэрээг байгуулсан өдрөөс хойш Хөрөнгө оруулагчийн хөрөнгөөр олж илрүүлсэн буюу баталгаажуулсан усны нөөц нь өөрийнх нь үйл ажиллагааны хэрэгцээг бүрэн хангаж илүү гарах нөхцөлд усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага Хөрөнгө оруулагчтай тохиролцож, **усны нөөцийн илүү гарсан хэсгийг бусад аж ахуйн нэгжид ашиглуулж болох** бөгөөд усны хайгуулын ажилд гаргасан зардлын тухайн аж ахуйн нэгжид ногдох хэсгийг Хөрөнгө оруулагчид уг аж ахуйн нэгжээр нөхөн төлүүлнэ”, 6.13.3-т “Хөрөнгө оруулагч нь **өөрийн хөрөнгөөр олж илрүүлсэн усны нөөцийг тухайн сум орон нутгийн ахуйн хэрэгцээнд, малчин өрхүүдэд болон хөдөө аж ахуйн үйл ажиллагааны зориулалтаар ашиглуулна.**” гэж тус тус заасан байна.

Оюутолгойн уулын баяжуулах үйлдвэрийн усны хэрэглээг хангаж байгаа “Гүний хоолойн газрын доорх усны ордын хайгуулын ажлын тайлан”-г 2008 онд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны хэрэг эрхлэх газрын Усны салбарын шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж, Байгаль орчин,

аялал жуулчлалын сайдын 2009 оны 22 дугаар тушаалаар баталсан. Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт орших Гүний хоолойн газрын доорх усны ордын нөөцийг үйлдвэрлэлийн В+С1 зэргээр 870 л/с гэж баталсан.

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4, 28.6, 28.9, 28.11, 29.1, 29.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Галба-Өөш Долоодын говийн сав газрын захиргаа "Оюу толгой" ХХК-тай ус ашиглах гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд "Оюу Толгой" ХХК-тай ус ашиглах гэрээ байгуулж ажилласнаар орон нутгийн төсөвт ус ашигласны төлбөрт 2017 онд 15,4 тэр бум төгрөг төлсөн байна.

**Асуулт 7. Таван Толгойн цахилгаан станцыг анхны Хөрөнгө оруулалтын гэрээ хийх үеэр тав, зургаан жилийн дотор барина гэсэн үүргийг Монголын тал хүлээж байсан. Гэтэл өнөөг хүртэл эхлээгүй учраас Оюу Толгой Хятад руу 200 км цахилгааны шугам татжээ. Иймээс бид эрчим хүчээ өндөр үнээр худалдан авч хэрэглэдэг. Сард цахилгааны төлбөр 7-8 сая ам.доллар гадагшаа урсгаж байгаа асуудлыг шийдвэрлэх боломж бий эсэх талаар;**

#### **Хариулт:**

ХеОГ-ний 7.3 дахь заалтад "Хөрөнгө оруулагч нь Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эхэлсэн өдрөөс хойш 4 /дөрөв/ жилийн дотор Оюу толгой төслийн эрчим хүчний нийт хэрэгцээгээ Монгол Улсын нутаг дэвсгэр дэх дор дурдсан нэг буюу түүнээс дээш эх үүсвэрээс сонгон хангана" гэж заасан байдаг. Үүнтэй холбоотой хэрэгжүүлэх боломжтой 2 хувилбар буюу Таван Толгой Цахилгаан станц (ТТЦС) болон Оюу Толгой Цахилгаан станц (ОТЦС) төслүүд байна.

Тавантолгойн нүүрсний орд газрыг түшиглэн барих цахилгаан станцын төслийг эхлүүлэхтэй холбоотой Засгийн газрын 2013 оны 71, 80, 129, 261 дүгээр тогтоолуудад үндэслэж, 2013 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн Эрчим хүчний сайдын 36 тоот "Төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулах" тушаалын дагуу Тавантолгойн цахилгаан станц барих төслийн нэгж байгуулагдсан. Улмаар Эрчим хүчний яам болон Төслийн нэгж нь "Оюу Толгой" ХХК-д Тавантолгойн цахилгаан станцын төсөлд хамтран ажиллах санал тавьснаар 2013 оны 5 дугаар сарын 17-ны өдөр Тавантолгойн цахилгаан станцын төслийн судалгаа хийх бэлтгэлийн үе шатанд "Хамтран ажиллах гэрээ" байгуулсан.

Түүнчлэн, "Төрийн өмчийн оролцоотой компани байгуулах тухай" Засгийн газрын 2013 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 129 дүгээр тогтоолоор Тавантолгойн нүүрсний орд газрыг түшиглэн барих цахилгаан станцын хүчин чадлыг 450 МВт байхаар тооцож, төслийг хэрэгжүүлэх тусгай зориулалтын компанийг гадаад, дотоодын хувийн хэвшлийн байгууллагуудын оролцоотойгоор үүсгэн байгуулахаар шийдвэрлэсэн.

Энэхүү төслийг хэрэгжүүлэх хүрээнд 2014 оны 6 дугаар сард хөрөнгө оруулах боломжтой сонирхогч компаниудад төслийн нөхцөл шаардлага, холбогдох харилцаануудыг зохицуулах гэрээ, ус, газрын болон бусад шаардлагатай зөвшөөрлүүд бүхий Арилжааны даалгаврыг боловсруулж хүргүүлсэн.

2016 оны 2 дугаар сард саналыг хүлээн авч дүгнэсэн бөгөөд Японы Марубени корпорацийг хөрөнгө оруулах боломжтой оролцогч гэж дүгнээд яриа

хэлэлцээ хийсэн.

Эрчим Хүчний Зохицуулах Хорооноос төслийн холбогдох тусгай зөвшөөрлүүдийг олгосон бөгөөд төслийн ТЭЗҮ, Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээ (БОННБҮ) болон бусад холбогдох техникийн суурь судалгаа, шинжилгээ, тайлангийн ажлууд хийгдээд байна.

Тавантолгой цахилгаан станцын хөрөнгө оруулалтын гэрээг 2016 оны 6 дугаар сарын 24-нд төсөл хэрэгжүүлэгч "Тавантолгой цахилгаан станц" ХХК Хөрөнгө оруулагч "Эм-Си-Эс пауэр" ХХК-тай байгуулсан.

Өнөөдрийн байдлаар төслийн төсөл хэрэгжүүлэгч "Тавантолгой цахилгаан станц" ХХК нь төслийн үндсэн худалдан авагч болох "Оюу Толгой" ХХК-тай цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээний яриа хэлэлцээ хийж байна.

Эрчим хүчний сайдаас 2016 оны 11 дүгээр сард Монгол Улсын Засгийн газраас Тавантолгойн цахилгаан станцын барилга угсралтын ажлыг 2017 оны эхний улиралд багтаан эхлүүлэхээр төлөвлөж байгаа тул хөрөнгө оруулах, цахилгаан эрчим хүч худалдах худалдан авах гэрээний талаарх хэлэлцээ 2016 оны 11 дүгээр сард багтаан дуусгаж, шийдвэрлэх шаардлагатай байгааг, 2017 оны 2 дугаар сард Хөрөнгө оруулагчдад 2017 оны 7 дугаар сард санхүүгийн хаалтаа хийж төслийн ажил эхэлсэн байх шаардлагатай ба дээр дурдсан хугацаанд ажлаа эхлэхгүй тохиолдолд Засгийн газрын зүгээс гэрээ цуцлах арга хэмжээг авах болохыг албан бичгээр мэдэгдсэн.

Төсөл хэрэгжүүлэгч компанийн талаас төслийн санхүүжилтийг шийдвэрлэхэд "Оюу Толгой" ХХК -ийн толгой компани "Рио Тинто" компаниас эрчим хүчний төлбөрийн баталгаа гаргуулах шаардлагатай бөгөөд төслийг хэрэгжүүлэх санхүүгийн боломжгүй байгаа талаар мэдэгдээд байгаа болно.

Төслийн эрчим хүчийг түр хугацаанд шийдэх зорилгоор ХөОГ-ний 7.2.1 заалтад *"...Оюутолгой төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах эрчим хүчний бүхий л хэрэгцээг дотоодоос, эсхүл гадаадаас хангах зорилгоор цахилгаан дамжуулах дэд бүтцийг /барилгын ажил гүйцэтгэх хугацаанд Оюу толгой ордоос Монгол-Хятадын Улсын хил хүртэлх 220 киловольт хүчдэлтэй цахилгаан дамжуулах шугам барих ажил үүнд орно/ барих"* гэж заасны дагуу эрчим хүчний шугамыг барьж байгуулан, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Эрчим хүчний компанитай "Эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ"-г 4 жилээр байгуулж, 2017 оны 7 дугаар сард үргэлжлүүлэн сунган эрчим хүч импортолж байна.

Иймд Монгол Улсын Засгийн газар болон "Оюу Толгой" ХХК хооронд байгуулсан "Өмнөд бүсийн эрчим хүчний салбарт хамтран ажиллах гэрээ"-ний талаар Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хуралдаанд танилцаад Монгол Улсын Засгийн газар, "Оюу Толгой" ХХК-тай байгуулсан "Өмнөд бүсийн эрчим хүчний салбарт хамтран ажиллах гэрээ"-г цуцлах талаар холбогдох талтай хамтран ажиллах, Монгол Улсын Засгийн газар, "Айвенхоу майнз лимитед, Рио Тинто интернэшнл холдингс лимитед хооронд байгуулсан "Хөрөнгө оруулалтын гэрээ"-ний 7.3-т заасны дагуу Оюутолгой төслийн нийт эрчим хүчний хэрэгцээг Монгол Улсын нутаг дэвсгэр дэх эх үүсвэрээс хангах талаарх хэлэлцээрийг холбогдох талтай хийж зохион байгуулалтын арга хэмжээ

авч ажиллахыг холбогдох сайдад даалгасан.

**Асуулт 8.** Оюутолгой орд газар бол Монгол Улсын түүхэн дэх хамгийн том уул уурхайн төсөл. Тийм ч учраас Улсын Их Хурал тус ордын тусгай зөвшөөрэл эзэмшигч "Оюу Толгой" ХХК-д төрийн эзэмшлийн доод хэмжээ 34 хувь байна хэмээн шийдвэрлэж, Засгийн газарт хөрөнгө оруулагчтай гэрээ хийх эрх олгосон билээ Сү.Батболдын Засгийн газар, хөрөнгө оруулагчдын хэлэлцээрээр Оюу Толгой ордын ашиглалтыг хоёр тусдаа буюу "Хөрөнгө оруулалтын гэрээ", "Хувь нийлүүлэгчийн гэрээ"-гээр Монгол Улсын Засгийн газар болон "Айвенхоу Майнз" компанийн хооронд Оюутолгой төсөлд эзэмших хувь болон орлого ашиг хуваарилах учир битүүлэг "нууц" ангилалд багтах гэрээг хийсэн. Тус Хувь нийлүүлэгчдийн гэрээнд маш ноцтой заалт багтсан нь "Оюу Толгой" ХХК-ний давуу эрхийн хувьцаатай заалт юм. Өөрөөр хэлбэл, Монголын тал "Оюу Толгой" ХХК-ийн зөвхөн ЭНГИЙН хувьцааны 34 хувийг эзэмших эрхтэй ба тус компани давуу эрхийн хувьцаа гаргасан тохиолдолд Монголын тал түүнийг худалдаж авах ЭРХГҮЙ байх заалт орсон байв. "Айвенхоу Майнз" компани давуу эрхийн хувьцаа гаргах шийдвэрийг бие даан гаргах эрхтэй бөгөөд энэ асуудалд Монгол Улсын Засгийн газар оролцох эрхгүй байсан. Тус гэрээний үндсэн дээр "Оюу Толгой" ХХК нь 2010-2011 оны бүх хөрөнгө оруулалтыг давуу эрхийн хувьцаа гаргах замаар санхүүжүүлэх төлөвлөгөөтэй ажиглаж байсан бөгөөд энэ гэрээ хэрэгжсэн тохиолдолд, "Айвенхоу Майнз" компани 80 хувийн давуу эрхийн хувьцаа гаргаснаар энгийн хувьцааны нийт жин 20 хувьд хүрч, энгийн хувьцааны 34 хувийг эзэмшигч Монголын талын эзэмшлийн хувь хэмжээ 6,8 хувь хүртлээ буурах "Нууц гэрээг" байгуулж байсныг УИХ-ын гишүүн С Эрдэнэ миний бие хэсэг гишүүдийн хамт илрүүлж хүчингүй болгуулж байсан билээ. Монгол Улсад маш хохиролтой, өөрсдийн хапаасыг зузаалах зорилготой, "Нууц" тодотголтой хөрөнгө оруулалтын дээрх гэрээг байгуулахаар санаархаж байсан этгээдүүд хэн байсан хийгээд, тэдэд ямар хариуцлага тооцсон талаар;

#### **Хариулт.**

#### **Оюутолгой төслийн гэрээнүүдийн талаар:**

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 308 дугаар тогтоолоор Монгол Улсын Засгийн газар болон "Айвенхоу майнз Монголий инк" ХХК, "Айвенхоу майнз лимитед", "Рио Тинто интернэшнл холдингс лимитед" компани хооронд байгуулах Оюутолгой ордыг ашиглах "Хөрөнгө оруулалтын гэрээ"-нд гарын үсэг зурах эрхийг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд, Сангийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдад олгож, 2009 оны 10 дугаар сарын 6-ны өдөр байгуулсан байдаг. Мөн өдөр "Эрдэнэс Монгол" ХХК болон "Айвенхоу Оюу Толгой (БиВиАй) Лтд", "Оюу Толгой Нидерланд Би.Ви", "Айвенхоу майнз Монголия инк" ХХК-ийн хооронд "Хувь нийлүүлэгчдийн гэрээ"-г байгуулсан бөгөөд 2011 оны 6 дугаар сарын 8-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулж, дахин тодотгосон байдаг.

#### **Бусад баримт бичгийн талаар:**

"Оюу Толгойн Далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө" (ДУББСТ) болон "Оюу Толгойн Далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн нэмэлт төлөвлөгөө" гэх баримт бичгүүдийг 2015 оны 5 дугаар сарын 18-ны өдөр талууд байгуулж, Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж

“Эрдэнэс Монгол” ХХК, “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн болон “Туркойс Хилл Ресурс Лимитед”, “Ти Эйч Ар Оюу Толгой ЛТД”, “Оюу Толгой Нидерланд Би Ви”, “Рио Тинто Интернэшнл Холдингс Лимитед”, “Оюу Толгой” ХХК-ийн холбогдох эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж баталгаажуулсан байдаг.

Монгол Улсын Засгийн газар болон Айвенхоу Майнз Монголия Инк, Айвенхоу Майнз Лимитед, Рио Тинто Интернэшнл Холдингс Лимитед компанийн хооронд байгуулсан хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах ажиллагаа нь гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй тухай мэдээлэлд 2017 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар эрүүгийн 170200165 дугаартай хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, Цагдаагийн ерөнхий газар, Авлигатай тэмцэх газрын дарга нарын 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/168, А/222 дугаар тушаалаар хамтарсан Ажлын хэсэг байгуулан мөрдөн байцаах ажиллагаа явуулж байна.

*Асуулт 9. 2018 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд Д Загджав "Рио Тинто"-той холбоотой асуудлаар хийсэн мэдээлэлдээ "Саяхан "Рио Тинто" компани Оюутолгойд түшиглэж, манай улсын нэрийг ашиглаж 5.4 тэрбум ам.доллар босгосон. Үүнээс нэг тэрбум ам.долларыг Оюутолгой төсөлд оруулаад, үлдсэн 4 4 тэрбум ам.долларыг Монголоос бусад хувьцаа эзэмшигчиддээ бүгдэд нь тарааж өгсөн" гэж мэдэгдсэн. Энэ мэдээллийн талаар болон Оюутолгой төслийн хувьд цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар.*

#### **Хариулт:**

“Далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө”-ний 5.5 дахь заалтын дагуу 2016 онд гуравдагч этгээдээс нийт 4,323 сая ам.долларын төслийн санхүүжилтийн зээл авч, хувь нийлүүлэгчдийн өмнөх зээл ба түүний хүүгийн төлбөрийн тодорхой хувийг төлсөн.

Мөн дээрх гэрээний заалтын дагуу Рио Тинтогийн зүгээс Оюутолгой төсөлд өмнөх хувь нийлүүлэгчдийг 2016 оны 10 дугаар сараас эхлэн эргэн дуудаж 720 сая ам.долларын хувь нийлүүлэгчдийн зээл, 280 сая ам.долларын хувьцааны санхүүжилт, нийт 1 тэрбум ам.долларыг хувьцааны санхүүжилт, хувь нийлүүлэгчдийн зээл хэлбэрээр босгосон (2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар) байна.

---ooOoo---



Хавсралт 1

НӨӨДТХНГ-ний заалт	Санхүүжилтийн төрөл		Санхүүжилт 2010-2016.06.29				Нэмэлт 2016-2017.12.31				Зээлийн эргэн төлөлт 2014-2016.06.29				Үлдэгдэл 2017.12.31						
			Үндсэн төлбөр		Хүү		Нийт		Үндсэн төлбөр		Хүү		Нийт		Үндсэн төлбөр		Хүү		Нийт		
<b>14. Гуравдагч этгээдийн зээл</b>	<b>Төслийн санхүүжилтийн зээл</b>		4,323	73	4,396	9	42	51	-	104	104	4,332	11	4,343							
	<b>Одоогийн хувь нийлүүлэгчдийн зээл</b>		680	322	1,002				680	322	1,002										
<b>13.1 Хувь нийлүүлэгчдийн зээл</b>	<b>Өрийн бичиг /РТ Алкан/</b>		195	82	277				195	82	277										
	<b>Грид зээл 1</b>		1,802	702	2,504				1,802	702	2,504										
	<b>Грид зээл 2</b>		4,141	311	4,452	720	218	938	1,332	169	1,501	3,529	360	3,889							
<b>11.1 Хувьцаа</b>	<b>Хувьцаа</b>		2,317		2,317	280		280				2,598		2,598							
	<b>Нийт</b>		<b>13,458</b>	<b>1,490</b>	<b>14,948</b>	<b>1,009</b>	<b>260</b>	<b>1,269</b>	<b>4,009</b>	<b>1,379</b>	<b>5,388</b>	<b>10,459</b>	<b>371</b>	<b>10,830</b>							
			<b>Үндсэн үйл ажиллагааны орлогоос</b>																		
			<b>Төслийн санхүүжилтээс</b>																		
			<b>Нийт</b>																		
			703 306 1,009																		
			3,306 968 4,274																		
			4,009 1,274 5,283																		